

#1 2011, 2012, 2013 оны шилдэг даатгагч	#2 2015 онд Тээврийн хэрэгслийн даатгалын хохирол төлөлтийн харьцаа үзүүлэлт	#3 2016 онд Жолоочийн хариуцлагын даатгалын хохирол төлөлтийн харьцаа үзүүлэлт	100 гаруй ажилчидтай	24 Салбар	10 % Зах зээлд эзлэх хувь	24 Үйл ажиллагаа явуулсан жил	238 Төлөөлөгчдийн тоо	54K Даатгуулагчийн тоо	6 Хамтран ажилладаг банкууд	20 Хамтран ажилладаг брокерууд
---	--	--	--------------------------------	---------------------	-------------------------------------	---	---------------------------------	----------------------------------	---------------------------------------	--

Компанийн тухай

Ард Даатгал компани нь 24 жилийн турш тасралтгүй тогтвортой үйл ажиллагаа явуулж, 24 салбар, 238 төлөөлөгч, 100 гаруй ажиллагсадтайгаар Монгол улсын даатгалын салбарын томоохон төлөөлөгч болон өргөжөөд байна.

Бид үйл ажиллагаандаа арилжааны даатгалын холбогдолтой хуулиуд, Санхүүгийн Зохицуулах Хорооноос гаргасан даатгалын багц дүрэм, журам, Даатгалын тухай хуулийн 9 дүгээр зүйл, 49 дүгээр зүйлд заасны дагуу эрх, үүргээ хүлээн хуулийн хүрээнд мэргэжлийн үйлчилгээг үзүүлэн ажилладаг.

Ард Даатгал компани харилцагч, даатгуулагчдын эрх ашгийг тэргүүн зэрэгт хүндэтгэн үзэж, даатгалын зах зээлд шударгаар өрсөлдөх нөхцлийг бүрдүүлэн, өрсөлдөөнд харш үйл ажиллагааг хориглон, эрх зүйн харилцааны хэм хэмжээг мөрдөн, зүй бус хэлцэлд оролцохоос татгалзаж, үйл ажиллагаандаа нээлттэй, шударга ёс зүйг баримтлан ажилладаг.

Хувьцаа эзэмшигчид

Ард Даатгал компанийн хувьцаа эзэмшигчид нь хөрөнгө оруулалт, банк санхүүгийн салбарын туршлага бүхий хуулийн этгээдүүд байдаг бөгөөд компанийн тогтвортой хөгжил, сайн засаглал, олон улсын тэргүүн туршлагыг Монгол улсын даатгалын зах зээлд нэвтрүүлэхийг байнга эрмэлзэж ирсэн.

Ард Санхүүгийн Нэгдэл ХК 95%

5% Энержи Интернэйшнл ХХК

Хураамж, нөхөн төлбөр, давхар даатгал /сая төг/

	Хураамж	Нөхөн төлбөр	Давхар даатгал
2017	10,355 +44.3%	4,063 +56.5%	3,302 +145.2%
2016	7,172 +21.7%	2,596 -32.2%	1,346 -26.9%
2015	9,160 -9.36%	3,829 +23.7%	1,842 +1.4%
2014	10,106	3,095	1,816

Зардлын харьцаа болон хохирлын харьцаа

	Зардлын харьцаа*	Хохирлын харьцаа*
2017	0.62 -4.6%	0.67 +52.2%
2016	0.65 +10.1%	0.44 -25.4%
2015	0.59 +3.5%	0.59 +43.9%
2014	0.57	0.41

Нийт хөрөнгө, нөөц сан /сая төг/

	Нийт хөрөнгө	Нөөц сан
2017	11,726 +22.9%	5,559 +27.6%
2016	9,541 +8.9%	4,355 -3.9%
2015	8,759 +1.2%	4,532 +8.8%
2014	8,689	4,163

*Харьцаа үзүүлэлтүүдийг орлогод тооцсон хураамжид харьцуулсан болно.

Даатгалын багцын мэдээлэл

	Хураамж		Нөхөн төлбөр		Давхар даатгал (2017)	
	2016	2017	2016	2017	хураамж	нөхөн төлбөр
Гэнэтийн осол, эмчилгээний даатгал	461 6.4%	1,101 10.6%	126 4.9%	111 2.8%	180	2
Хөрөнгийн даатгал	1,281 17.9%	4,236 40.9%	201 7.7%	399 9.8%	1,874	45
Авто тээврийн хэрэгслийн даатгал	921 12.8%	1,327 12.8%	756 29.1%	670 16.5%	-	-
Ачаа тээврийн даатгал	283 3.9%	227 2.2%	19 0.7%	118 2.9%	43	-
Барилга угсралтын даатгал	295 4.1%	451 4.4%	9 0.4%	1,304 32.2%	282	1,278
Газар тариалангийн даатгал	- 0.0%	43 0.4%	- 0.0%	211 5.3%	37	205
Мал амьтдын даатгал	39 0.5%	113 1.1%	- 0.0%	2 0.0%	36	-
Агаарын хөлгийн даатгал	1,180 16.4%	37 0.3%	67 2.6%	- 0.0%	368	-
Хариуцлагын даатгал	920 12.8%	500 4.8%	45 1.7%	113 2.7%	468	-
Санхүүгийн даатгал	30 0.4%	12 0.1%	344 13.3%	314 7.7%	1	-
Жолоочийн хариуцлагын даатгал	1,762 24.6%	1,833 17.8%	1,029 39.6%	753 18.5%	12	-
Зээлийн даатгал	- 0.0%	476 4.6%	- 0.0%	67 1.6%	-	-
Нийт	7,172 100.0%	10,355 100.0%	2,596 100.0%	4,063 100.0%	3,302	1,530

Төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлт

2017	111.47%
2016	102.01%

Тайлбар: Төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлтийг хангасан болно.

Давхар даатгал

Ард Даатгал компани нь давхар даатгалын үйл ажиллагааг Санхүүгийн Зохицуулах Хорооны дүрэм журам, Монгол улсын бусад холбогдох хууль тогтоомжтой нийцүүлэн олон улсад мөрдөгддөг хэм хэмжээний дагуу явуулдаг.

Шууд даатгагчийн хувьд бид:

- Эд хөрөнгийн даатгал
- Барилга угсралтын ажлын даатгал
- Агаарын хөлгийн иж бүрэн даатгал
- Байгууллагын хариуцлагын даатгал
- Мэргэжлийн хариуцлагын даатгал
- Ачаа тээврийн даатгал
- Гэнэтийн ослын даатгал
- Олон улсын эрүүл мэндийн даатгал зэрэг даатгалын төрлүүдээр дэлхийн нэр хүнд бүхий томоохон давхар даатгагчдад шууд болон брокероор дамжуулан олон улсын стандартын дагуу, тухайн эрсдэлийн онцлогт тохирсон найдвартай давхар даатгалын хамгаалалт авч, эрсдэлийн удирдлагын үйлчилгээг шуурхай үзүүлж байна.

• 2016 оноос эхлэн UIB Singapore брокероор дамжуулан Hannover re компанитай трити гэрээ байгуулан ажиллаж байгаа нь Ард даатгал компанийн эрсдэл даах чадавхийг нэмэгдүүлэхээс гадна харилцагчдад найдвартай өндөр түвшний хамгаалалтыг бий болгож байгаа юм.

• 2017 оны хувьд бид Hannover re, MSH International компаниудтай хамтран ARD MEDICARE олон улсын эрүүл мэндийн даатгалын бүтээгдэхүүнийг амжилттай нэвтрүүлсэн нь манай харилцагч, үйлчлүүлэгчдийн талархлыг хүлээсээр байна. Энэхүү бүтээгдэхүүн нь дэлхийн 200 орны 330,000 гаруй эмнэлгээр үйлчлүүлэх боломжийг олгож байгаа бөгөөд өргөн хүрээ бүхий хамгаалалтыг харьцангуй хямд үнээр авах боломжийг харилцагчдад олгож буй бүтээгдэхүүн юм.

• Мөн 2017 онд манай компани Хөдөө Аж Ахуйн Давхар Даатгал ХК-тай хамтран газар тариалангийн даатгалыг Монгол улсын даатгалын зах зээл дээр анх удаа хэрэгжүүлэх ажилд амжилттай оролцож дөрвөн аж ахуйн нэгжид 211 сая төгрөгийн нөхөн төлбөр олгожээ.

Манай гэрээнд түгээмэл оролцож буй давхар даатгагч болон брокерууд



Түүхэн замнал

- 2017** • Нөхөн төлбөрийг тухайн өдөрт нь олгодог болов.
- “Хөдөө Аж Ахуйн Давхар Даатгал” ХК-тай хамтран Тариалангийн даатгал хэрэгжүүлж эхлэв.
- 2016** • Малын индексжүүлсэн даатгалын үйлчилгээг үзүүлж эхлэв.
- Давхар даатгалын трити гэрээг ХБНГУ-ын давхар даатгагч Hannover re-тэй байгуулав.
- Hannover re болон MSH International компаниудтай хамтран олон улсын эрүүл мэндийн даатгалыг нэвтрүүлэв.
- 2015** • 70 мянган харилцагчдын мэдээллийг агуулсан даатгалын цахим мэдээллийн санг үүсгэв.
- Ард Санхүүгийн Нэгдэл ХК хөрөнгө оруулагч болов.
- 2014** • Монгол Улсын Татварын Ерөнхий Газрын дээд шагнал “Хөх дэвтэр” гардав.
- 20 жилийн ойн баяраа харилцагч, даатгуулагчдынхаа хамтаар ёслол төгөлдөр тэмдэглэв.
- 2013** • МҮХАҮТ “Оны шилдэг даатгалын компани”-аар дахин шалгаруулав.
- 2012** • Grand Expo-ийн “Оны шилдэг даатгалын компани” болов.
- МҮХАҮТ “Оны шилдэг даатгалын компани”-аар шалгаруулав.
- 2011** • Гранд Даатгал ХХК-ийг өөртөө нэгтгэв.
- “Оны шилдэг даатгалын компани”-аар тодров.
- Оюу Толгой төслийн бүтээн байгуулалтанд оролцож эхлэв.
- 2010** • “International Quality Era Award” (Switzerland, Geneva) шагнал гардав.
- Банк, санхүүгийн байгууллагуудтай хамтран ажиллаж эхлэв.
- Агаарын хөлгийн даатгалын үйлчилгээг үзүүлж эхлэв.
- 2008** • Санхүүгийн Зохицуулах Хорооны “Оны шилдэг даатгалын компани”-аар шалгарав.
- 2004** • Их Британийн “Omni Whittington Group” хөрөнгө оруулав.
- 2000** • Монгол улсын “ТОП-5” даатгалын компанийн нэг болов.
- 1994** • Ард Даатгал ХХК үүсгэн байгуулагдав.

Бүтээгдэхүүн үйлчилгээ

Ард Даатгал компани нь ердийн даатгалын үйл ажиллагаа явуулдаг бөгөөд Санхүүгийн Зохицуулах Хорооноос тогтоосон сайн дурын болон албан журмын даатгалын хэлбэрээр 50 гаруй төрлийн даатгалын бүтээгдэхүүн үйлчилгээг үзүүлж байна.

Мөн жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын хэрэгжүүлэгч ууган компаниудын нэг юм.

